

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2017 оны 03 дугаар сарын 07-ны
өдрийн 7/ дугаар тогтоолын хавсралт

**“МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ПАРК”
ТӨРИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТОЙ
ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ДҮРЭМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү дүрмийн зорилго нь үйлдвэрийн газрын үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох, удирдлага, хяналт, үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрхийг тодорхойлох, түүнийг өөрчлөн байгуулах, бүртгүүлэх болон холбогдох үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохицуулахад оршино.

1.2. “Мэдээлэл, технологийн үндэсний парк” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар (цаашид “үйлдвэрийн газар” гэх) нь төрөөс мэдээллийн технологи, инновацийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, мэдээллийн технологи, инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйлдвэрлэл эрхлэх, хөгжүүлэх, гарааны компанийг бойжуулан төлөвшүүлэх, шилдэг энтерпренёрыг бэлтгэх, үндэсний брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээ, Монгол контент бүтээх, гадаад аутсорсингийн үйл ажиллагааг дэмжих чиг үүрэг бүхий өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар мөн.

1.3. Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь харилцаа холбоо, мэдээлэл, технологийн салбарын хууль тогтоомж, дээд шатны байгууллагын шийдвэр, бодлого, чиглэлийн хүрээнд үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллана.

1.4. Үйлдвэрийн газрын үүсгэн байгуулагч нь Засгийн газар байна.

1.5. Үйлдвэрийн газар нь үйл ажиллагаандаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Иргэний хууль, Шилэн дансны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Инновацийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрмийг мөрдөнө.

Хоёр. Үйлдвэрийн газрын оноосон нэр, оршин байгаа газар

2.1. Төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын оноосон бүтэн нэр нь “Мэдээлэл, технологийн үндэсний парк” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, товчилсон нэр нь “МТҮП” ТӨААТҮГ байна.

2.2. Үйлдвэрийн газрын байршил нь түүний удирдлагын байрлаж буй, улсын бүртгэлд бүртгүүлсэн хаягаар тодорхойлогдоно. Үйлдвэрийн газрын оршин байгаа газар нь: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 8 дугаар хороо, Багатойруу 49.

2.3. Үйлдвэрийн газрын шуудангийн хаяг:

Монгол Улс, Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо
Улаанбаатар 14200
Утас: 976-11-327123
Факс: 976-11-312918
2.4. Цахим хаяг: info@itpark.mn

Гурав. Үйлдвэрийн газрын бэлгэдэл, тэмдэг

3.1. Үйлдвэрийн газар нь өөрийн бэлгэдэл, барааны тэмдэгтэй байхаас гадна албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ.

3.2. Бэлгэдэл, барааны тэмдгийн загварыг Захирлын тушаалаар батлах бөгөөд оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлнэ.

3.3. Үйлдвэрийн газрын албан ёсны шийдвэр, албан бичиг, гэрээ, хэлцлийг захирал баталгаажуулна.

3.4. Үйлдвэрийн газрын тэмдгийг захирал, эсхүл захирлаас итгэмжлэн хариуцуулсан этгээд түшиж, ашиглалт, хамгаалалт, хадгалалтыг хариуцна.

Дөрөв. Үйлдвэрийн газрын үндсэн зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл

4.1. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр үйлдвэрийн газрыг өөрчлөн байгуулах, татан буулгахаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд үйлдвэрийн газар нь үйл ажиллагаагаа хугацаагүйгээр явуулна.

4.2. Үйлдвэрийн газрын алсын хараа нь экспортын баримжаатай, өндөр технологийн үйлдвэрлэлийг бий болгох замаар Монгол Улсын эдийн засгийн өрсөлдөх чадварыг сайжруулах, мэдээлэл, технологи, инновацийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх бүс нутгийн хэмжээний парк болоход оршино.

4.3. Үйлдвэрийн газрын үндсэн зорилго нь төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээний байгууллагын хамтын ажиллагаанд суурилсан инновацийн тогтолцоог хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах өрсөлдөх чадвар бүхий үндэсний компаниудыг төлөвшүүлэх, мэдээллийн технологийн өндөр ур чадвартай боловсон хүчнийг хөгжүүлэхэд оршино.

4.4. Үйлдвэрийн газар нь дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

4.4.1. Монгол Улсад мэдээллийн технологид суурилсан аюулгүй, найдвартай, дэвшилтэт нийгмийг бий болгоход энтерпренёр, гарааны компани, инкубаторын компаниудын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, чиглүүлэх, олон улсад өрсөлдөх чадвар бүхий компани, хүний нөөцийг бэлтгэх;

4.4.2. Хөдөлгөөнт холбооны технологид суурилсан агуулга хөгжүүлэгчдийг бэлтгэж, гадаад дотоодын зах зээлд бүтээгдэхүүнээ гаргахад нь дэмжлэг үзүүлэх;

4.4.3. Төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээний байгууллагын мэдээлэл, технологийн хүний нөөцийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, олон улсын жишигт нийцсэн ур чадвар, стандартын тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх;

4.4.4.Дотоод, гадаадын их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, төр, хувийн хэвшилтэй хамтран ажиллах, хамтын ажиллагааны уялдаа холбоог сайжруулах;

4.4.5.Мэдээлэл, технологийн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах боломж бүхий таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, салбарын төвлөрөл бий болгох.

4.5.Үйлдвэрийн газар нь дараах үндсэн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулна:

4.5.1.Мэдээллийн технологийн бизнес, инновацийг дэмжих;

- Мэдээллийн технологийн инкубатор;
- Төсөл хөтөлбөр;
- Гарааны компанийн хурдасгуур хөтөлбөр хэрэгжүүлэх /startup accelerator program-богино хугацаанд эрчимтэй хэрэгжиж, гарааны компанийг дараагийн түвшинд хүргэдэг хөтөлбөр, Y-combinator, TechStars, 500 startup гм)
- Цахим засаглал, статистикийг хөгжүүлэн ажиллах

4.5.2.Төрийн албан хаагч, иргэдэд чиглэсэн мэдээллийн технологийн сургалт явуулах;

4.5.3.Өндөр технологийн судалгаа, хөгжүүлэлт, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх;

4.5.4.Салбарын зах зээлийн судалгаа хийх;

4.5.5.Хууль тогтоомжоор хориглоогүй бусад үйл ажиллагаа.

4.6.Үйлдвэрийн газар нь тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг холбогдох эрх бүхий байгууллагын зохих зөвшөөрлөөр эрхэлнэ.

Тав. Үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрх

5.1.Үйлдвэрийн газар нь эд хөрөнгийн талаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

5.2.Үйлдвэрийн газар нь үндсэн хөрөнгийг данснаас хасах буюу борлуулах, устгах саналаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргана.

5.3.Дангаар болон хамтран хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр, судалгаа хөгжүүлэлтийн ажлын үр дүнд бий болсон биет бус хөрөнгийг гэрээнд заасны дагуу эзэмшиж, захиран зарцуулж болно.

5.4.Мэдээллийн технологийн инкубаторын үйлчилгээ үзүүлэх, гарааны компанийн хурдасгуур хөтөлбөр хэрэгжүүлэхдээ гарааны компани болон инкубаторын компаниудаас холбогдох хууль тогтоомжийн дагуу хувь эзэмшиж, болно.

Зургаа. Үйлдвэрийн газрын удирдлага

6.1.Үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг Захирал удирдана. Үйлдвэрийн газрын захирлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн хууль тогтоомжид заасны дагуу томилж, чөлөөлнө.

6.2. Үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтэц, цалингийн сан, орон тооны дээд хязгаарыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар батална.

6.3. Үйлдвэрийн газрын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, үйлдвэрийн газрыг хөгжүүлэх бодлого, дунд хугацааны бизнес төлөвлөгөө, хөтөлбөрийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар батална.

6.4. Захирал нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай контрактын гэрээ байгуулан ажиллах бөгөөд гэрээний биелэлтийг бүрэн хариуцна.

6.5. Захирал нь дэргэдээ үйлдвэрийн газрын бүтцийн нэгжийн удирдлагаас бүрдсэн, захиралд зөвлөх үүрэг бүхий Захирлын зөвлөл ажиллуулж болно. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Захирал батална.

6.6. Захирал нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас гадна дор дурдсан эрх, үүрэгтэй байна:

6.6.1. үйлдвэрийн газрыг гадаад, дотоодод төлөөлөх, үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулах;

6.6.2. холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үйлдвэрийн газрын дүрэм, зорилтын санал, бизнес төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангах;

6.6.3. гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, үйлдвэрийн газрын хэвийн үйл ажиллагааг хангасны үндсэн дээр санхүү, төлбөрийн чадвар, нэр хүндийг бүх талаар дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулах;

6.6.4. үйлдвэрийн газрыг мэргэжил арга зүй, ажлын дадлага, туршлагаа бүрэн дайчлан, удирдан ажиллах;

6.6.5. үйлдвэрийн газрын эд хөрөнгөтэй холбоотой асуудлаар буюу шинээр худалдан авах болон акталж, устгах, худалдах, түрээслүүлэх, шилжүүлэх, үндсэн хөрөнгийн асуудлыг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

6.6.6. гадаад, дотоодын болон олон улсын байгууллага, иргэдтэй үйл ажиллагааны чиглэлээр холбоо тогтоох, гэрээ хэлцэл байгуулах, шинжлэх ухааны байгууллага, нийгэмлэг, холбоонд гишүүнээр элсэх;

6.6.7. холбогдох хууль тогтоомжоор зөвшөөрсөн нөхцөлд үйлдвэрийн газрын мэдээллийн технологийн инкубатор, хурдасгуурын үйлчилгээнд хамрагдах иргэн, баг, аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах болон хяналт-шинжилгээ хийж үнэлгээ өгөх, журмыг боловсруулж, батлан мөрдүүлэх;

6.6.8. тогтвортой ажиллах бүтээлч хамт олныг бүрдүүлж, ажлын чанар, үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах;

6.6.9. үйлдвэрийн газрын бүтэц орон тоонд тохирсон бүтцээр орон тоог хуваарилах, өөрчлөлт хийх, цалингийн бүдүүвч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох;

6.6.10. төсөв, хөрөнгийг төвлөрүүлэх, хөрөнгийг үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасны дагуу захиран зарцуулах, төсөв санхүүгийн төлөвлөлт, хуваарилалт, зарцуулалтад хяналт тавих;

6.6.11. ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг бүрдүүлэх.

Долоо. Үйлдвэрийн газрын санхүү, бүртгэл, тайлан

7.1.Үйлдвэрийн газар нь өөрийн эд хөрөнгийг үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж ашиглах эрхтэй. Үйлдвэрийн газар нь өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үндсэн хөрөнгө олж авах, данснаас хасах, шилжүүлэх, актлах саналаа холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

7.2.Нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан тэнцэл гаргах ажлыг Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу явуулна. Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баталгаажсан баримтыг үндэслэн дэлгэрэнгүй ба хураангуй бүртгэл хөтлөн тайлан тэнцлийг улирлаар гаргаж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт заасан хугацаанд хүргүүлнэ.

7.3.Эд хөрөнгийн тооллогыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу явуулж байна.

7.4.Үйлдвэрийн газар нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж, Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу жил бүр гаргаж, аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулна.

7.5.Үйлдвэрийн газрын санхүүгийн жил нь тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, мөн оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно.

7.6.Үйлдвэрийн газрын санхүүгийн тайланг шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор гэрээний үндсэн дээр аудиторыг сонгон ажиллуулна.

7.7.Үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд болон эд хөрөнгө, санхүү, нягтлан бодох бүртгэл, тооцоонд тавих өөрийн болон хөндлөнгийн хяналтыг зохих хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлнэ.

Найм. Үйлдвэрийн газрын санхүүжилт, санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан

8.1. Үйлдвэрийн газрын орлого нь дараах санхүүгийн эх үүсвэрээс бүрдэнэ:

8.1.1.Батлагдсан үнэ, тариф, гэрээний дагуу үзүүлсэн үйлчилгээнээс олсон орлого;

8.1.2.Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагатай хамтарч ажиллах гэрээний дагуу үзүүлсэн ажил, үйлчилгээний орлого;

8.1.3.Гадаад улс орнуудын зээл, буцалтгүй тусламж, төсөл хөтөлбөрийн санхүүжилт;

8.1.4.Мэдээлэл, технологи, инноваци, инкубатор, хурдасгуурын үйл ажиллагаа явуулахад зориулж жил бүрийн улсын төсвөөс олгох хөрөнгө;

8.1.5.Дангаар болон хамтран эзэмшдэг оюуны өмч, бүтээлийг эдийн засгийн эргэлтэнд оруулж олсон орлого;

8.1.6.Гарааны болон инкубаторын компаниудаас эзэмшиж буй хувь, хувьцаанаас олох орлого;

- 8.1.7.Хууль тогтоомжийн дагуу олгогдсон улсын төсвийн санхүүжилт;
8.1.8.Хууль тогтоомжинд заасан бусад эх үүсвэр.

8.2.Үйлдвэрийн газар нь санхүүгийн үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж, олон улсын нягтлан бодох бүртгэлийн дагуу хөтөлж, холбогдох байгууллагад тайлагнана.

8.3.Үйлдвэрийн газрын санхүүгийн тайлангийн үнэн зөвийг захирал, ерөнхий нягтлан бодогч хариуцна.

8.4.Захирал нь төрийн захиргааны холбогдох байгууллагад тухайн жилийн үйл ажиллагаа, зохион байгуулалтын бүтэц, зарцуулсан хөрөнгө санхүү, үр дүнг тодорхой тусгасан тайлан хүргүүлэх бөгөөд тайланд дараах зүйлийг тусгана:

8.4.1.Тайлангийн хугацаанд үйлдвэрийн газрын эрхлэн явуулсан үндсэн үйл ажиллагааны талаархи танилцуулга, гарсан өөрчлөлт болон эдгээр үйл ажиллагааны үр дүнгийн байдал, түүний өөрчлөлт;

8.4.2.Тайлангийн хугацаанд үйлдвэрийн газрын албан тушаалтан, ажиллагсад олгосон шагнал урамшил, удирдлагын зардлын хэмжээ;

8.4.3.Шаардлагатай бусад мэдээлэл, тайлбар.

Ес. Үйлдвэрийн газрын бичиг баримтыг хадгалах

9.1.Үйлдвэрийн газар нь албан хэрэг хөтлөлт, архивын нийтлэг журмыг мөрдөн ажиллах бөгөөд дараах бичиг баримтыг байнга хадгална:

9.1.1.Үйлдвэрийн газрын дүрэм, дүрэмд орсон нэмэлт, өөрчлөлт, үйлдвэрийн газрыг байгуулах эрх бүхий байгууллагын шийдвэр, тогтоол, улсын бүртгэлийн гэрчилгээ болон бусад гэрчилгээ сертификат;

9.1.2.Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, түүнд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмж;

9.1.3.Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримт, түүнд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох бичиг баримт;

9.1.4.Үйлдвэрлэл, технологи, норм норматив, түүнтэй холбогдох дүрэм, журам, заавар, бусад бичиг баримт;

9.1.5.Хурлын тэмдэглэл, шийдвэр, захирлын тушаал, шийдвэр;

9.1.6.Шаардлагатай бусад баримт бичиг.

9.2.Дээрх бичиг баримтыг холбогдох этгээдээс хүлээн авч хадгалах, эрх бүхий этгээдэд танилцуулах, архивт шилжүүлэх ажлыг зохих журмын дагуу эрхлэн гүйцэтгэнэ.

Арав. Үйлдвэрийн газрыг татан буулгах

10.1.Үйлдвэрийн газрыг Иргэний хууль болон бусад хууль тогтоомжид заасан үндэслэл журмыг баримтлан төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр татан буулгах эсхүл өөрчлөн зохион байгуулна.

Арван нэг. Бусад

11.1.Энэхүү дүрэмд тусгагдаагүй бусад асуудлыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор

зохицуулна.

11.2.Энэхүү дүрэм нь улсын бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.

11.3.Үйлдвэрийн газрын дүрэмд орсон нэмэлт, өөрчлөлтийг хууль тогтоомжид заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.

---oOo---